



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

**11**  
АНГИ

# МОНГОЛЫН ТҮҮХ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....



**САНАМЖ**

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу балын харандаагаар будаарай.

1. XVII зууны эхэн үед амьдарч байсан Монголын түүхэн зүтгэлтэн эдгээрээс аль нь вэ?  
A. Өгэдэй хаан      B. Эсэн тайш      C. Галданцэрэн хаан      D. Батмөнх даян хаан
2. XX зууны эхэн үеийн Монголын түүхэнд холбогдох үйл явдал аль вэ?  
A. Манж нар бослогыг даруулахаар томилсон Улиастайн жанжин Цэнгүнжав Хотгойдын зүг дайрав.  
B. 47 сурагчтай анхны иргэний сургуулийг Нийслэл Хүрээнд байгуулав.  
C. Амарсанаа Бор тал гэдэг газар өөрийн бие Зүүнгарын хаанд өргөмжлөв.  
D. Сайн ноён хан аймгийн олон хошууны цэргүүд Онолтоор удирдуулсан бослого гаргажээ.
3. XVII зууны үеэс Буриадын нутагт хүч түрэн орж алба гувчуур авах, эзлэн захирах бодлого явуулж, бэхлэлт шивээ барин суурьших болсон улс аль нь вэ?  
A. Манж-Чин улс      B. Зүүнгар улс      C. Халх Монгол      D. Оросын хаант улс
4. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн дотоод шалтгааныг олно уу.  
A. Мин улсын хагалан бутаргах бодлого нөлөөлсөн  
B. Аймаг тэргүүлсэн хан, ноёд хувийн ашиг сонирхлыг илүүд үзсэн  
C. Манж улс хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлогоо идэвхжүүлсэн  
D. Хаант Орос улс газар нутгаа тэлэх бодлого явуулж байсан
5. Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү.  
Сайн ноён аймгийн олон хошууны цэргүүд 1880 оны 7-р сарын 12-нд ..... удирдуулсан бослого гаргажээ.  
A. Энхтайванаар      B. Цогдалайгаар      C. Чингүнжаваар      D. Онолтоор
6. Хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдийн пүүсийг эвдэн сүйтгэж, өрийн дансыг устгаж, Манжийн эрхшээлийн эсрэг тэмцсэн түүхэн зүтгэлтэн хэн бэ  
A. Чин ван Эринчиндорж      B. Бүрнэ, Лувсан нар  
C. Тогтох тайж      D. Онолт
7. 1755 онд Манж Чин улс их цэргийн хүчээр Зүүнгар улсын эсрэг довтолж, Зүүнгар улсын ямар хааныг барьж олзолсон бэ?  
A. Галдан бошигт хаан      B. Түшээт хан Чахундорж      C. Даваач хаан      D. Төрбайх
8. 1657 онд Халимагууд ямар улстай цэргийн холбооны гэрээ байгуулсан бэ?  
A. Манж      B. Орос      C. Монгол      D. Төвөд
9. Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгмийн доод давхаргад ямар хүмүүс ордог байсан бэ?  
A. Засаг ноёд      B. Хамжлага      C. Шавь      D. Гэрийн боол

10. Манжийн эрхшээлийн үеийн Монголын ноёд, тайж нарын харьяат ардыг юу гэдэг байсан бэ?  
A. Хамжлага B. Шавь C. Ван D. Хутагт лам
11. 1920 оны Богдын тэргүүлсэн Засгийн газрын үйл ажиллагаанд аль нь хамаарах вэ?  
A. Цагаантны цэрэгт хүчин зүтгэж байсан монголчуудыг талдаа татах  
B. МАН, Түр засгийн төлөөний түшмэлийг хошуу, шавьд томилон суулгахаар шийдсэн.  
C. Ардын журамт цэргийг өргөтгөх хүч нөлөөгөө нэмэгдүүлэх  
D. АТЗГ-тай сөргөлдөж байсан тул яваандаа зэвсэгт мөргөлдөөнд зайлшгүй хүрнэ хэмээн бэлтгэлээ хангаж байсан.
12. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.  
НТӨ НТ 1919 он 1967 он
- 
- A. Хятадын ерөнхийлөгч Монголын автономийг цуцлах зарлиг гаргав. Монголд үндэсний телевизийн нэвтрүүлэг эхлэв.  
B. Засгийн газраас төр шашны хэргийг тусгаарлан явуулах тухай хууль баталжээ. Атрын анхдугаар аян өрнөв.  
C. Монгол Улсад Бүгд Найрамдах засаглал тогтов. НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болов.  
D. Хамжлагын харилцааг халах шийдвэр гаргав. БНМАУ гурав дахь Үндсэн хуулиа батлав.
13. Монголын ард түмнээс өөрийн хөрөнгөөр ЗХУ-д захиалан хийлгэж бэлэглэсэн “танкын бригад”-ын нэр юу вэ?  
A. Хөх Монгол B. Хувьсгалт Монгол  
C. Бүхнийг фронтод D. Монгол Ард
14. Атарын анхдугаар аян хэдэн оноос эхэлсэн бэ?  
A. 1961 он B. 1976 он C. 1959 он D. 1981 он
15. Монголын урлаг, уран сайхны хөгжилд аль нь хамаарах вэ?  
A. Монголын эрдэмтэд сансар судлалын “Интеркосмос” программыг хэрэгжүүлэх ажилд гар бие оролцсон  
B. Сургуулийн бүтцийг 3+5+2 болгон өөрчилсөн  
C. 1970 он гэхэд хүн амын 89,3% нь бичиг үсэг тайлагдсан  
D. 1988 онд “Мандухай сэцэн хатан” кино дэлгэцнээ гарсан
16. БНМАУ 1963 онд Австри улстай дипломат харилцаа тогтоосон. Энэ жил дипломат харилцаа тогтоосны хэдэн жилийн ой болох вэ?  
A. 59 жилийн ой B. 61 жилийн ой C. 60 жилийн ой D. 62 жилийн ой
17. Дээд, Доод танхим бүхий Улсын хурлыг 1914 онд байгуулжээ. Энэ үйл явдал “Олноо өргөгдсөн”-ий хэддүгээр онд болсныг тооцоолно уу.  
A. 13 дугаар он B. 14 дугаар он C. 3 дугаар он D. 4 дүгээр он

18. Монгол улсын хөгжлийн талаарх Д.Сүхбаатарын үзэл баримтлал аль нь вэ?  
А. Уламжлал, шинэчлэлийг хослуулах, ардчилсан чиг шугамыг баримтлах  
В. Монголд Бүгд Найрамдах засаг тогтоох, хүн төрөлхтний туулж ирсэн жам ёсны дагуу, шат дараалан хөгжих ёстой.  
С. Ардын эрхт, хэмжээт цаазат засаг тухайн цаг үед тохиромжтой  
D. Монгол улс социалист чиг баримжаагаар хөгжих
19. Шинэ эргэлтийн бодлогын үр дүн аль нь вэ?  
А. Төрөөс худалдааны салбарт тавих хяналтыг хүчтэй болгон хувийн худалдааг хавчих болсон  
В. Ард иргэд хэвийн аж төрөх боломжгүй болсноос нутгаа орхин хил даван нүүж эхэлсэн  
С. Нөхөрлөл, коммун, артель нэгдэл хэмээх дундын өмчтэй хоршоолол хэдэн зуугаар нь байгуулсан  
D. Мал сүргийг өсгөх уян хатан бодлогын үр дүнд ганцхан жилийн дотор малын тоо 3.3 саяар өссөн
20. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо огцрох шийдвэрийг хэзээ гаргасан бэ?  
А. 1992.01.13                      В. 2008.07.01                      С. 1990.03.09                      D. 1989.12.10
21. 1992 оны 1 сарын 13-нд батлагдсан шинэ “Үндсэн хууль”-д төрийн эрх барих дээд байгууллагыг юу гэж заасан бэ?  
А. Засгийн газар                      В. Улсын дээд шүүх  
С. Үндсэн хуулийн цэц                      D. Улсын их хурал
22. Засгийн газраас “Албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай”-ыг тогтоолыг хэзээ гаргасан бэ?  
А. 1992 он                      В. 1998 он                      С. 1990 он                      D. 2003 он
23. 1990 онд Монголд ардчилсан хувьсгал гарахад нөлөөлсөн гадаад шалтгааныг тодорхойлно уу.  
А. ЗХУ-аас эдийн засгийн тусламж, дэмжлэг нэмэгдсэн  
В. ЗХУ-ын улс төр, цэргийн хүч нөлөө буурсныг ашигласан  
С. Социалист системийн хямрал, задрал  
D. Нэгдсэн Үндэсний Байгууллагын гишүүн орон болсон

24. Монголын түүх нь үечлэлийг үйл явдалтай нь зөв харгалзуулсан нь аль вэ?

- |                                    |   |
|------------------------------------|---|
| a. Монголын эзэнт гүрний үе        | 1. Шинэ засгийн бодлого хэрэгжүүлэв.            |
| b. Манжийн эрхшээлийн үеийн Монгол | 2. Тангарагийн гэрээг батлав.                   |
| c. Богд хаант Монгол улсын үе      | 3. Улаанбаатар хотод 4-р цахилгаан станц барив. |
| d. БНМАУ-ын үе                     | 4. Үндсэн хуулийн цэц байгуулагдав.             |
| e. Монгол улсын үе                 | 5. Юань улс “цаасан мөнгө” гаргав.              |
- A. a-5 b-1 c-2 d-3 e-4                      B. a-5 b-2 c-1 d-3 e-4  
C. a-5 b-1 c-2 d-4 e-3                      D. a-5 b-1 c-2 d-3 e-4

25. БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, бодлогуудтай холбоотой үйл явдлыг зөв харгалзуулсан нь аль вэ?

a. Шинэ эргэлтийн бодлого	1. МАХН марксизм-ленинизмын онолыг нийгмийн хүрээнд тулган хүлээлгэв.
b. Нийгмийн амьдралд гарсан өөрчлөлт	2. 1959-1960 онд 18.5 тонн төмс хураан авав.
c. Эдийн засагт гарсан өөрчлөлт	3. Орны цагаан хэрэглэл хэргэлдэг болов.
d. Атарын анхдугаар аян	4. Нэг нэгдэл дунджаар 43 мянган малтай байв.
e. Соёлын довтолгоо	5. 1932 оны 6-29-30нд МАХН-ын ТХ, Хянан байцаах Төв Комиссын хамтарсан онц III бүгд хурал хуралдав.

- A. a-5 b-1 c-2 d-4 e-3                      B. a-5 b-1 c-4 d-2 e-3  
C. a-1 b-3 c-4 d-2 e-5                      D. a-1 b-3 c-2 d-5 e-4